



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/161

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 8/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутагт “Наурыз”-ын баярыг тохиолдуулан залуучуудын оролцоог ханган зохион байгуулах арга хэмжээнд зарцуулах төсвийг 8,0 сая төгрөг /найман сая/-өөр хавсралтаар баталсугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулах 8,0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.25 дахь заалтын “Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр”-өөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Казах үндэсний зан, заншил, соёлын өв уламжлалыг сурталчлан таниулах арга хэмжээнд залуучуудын оролцоог өргөнөөр ханган, өндөр түвшинд зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ажлын хэсгийн ахлагч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
03 дугаар сарын 14-ний өдрийн
А/161 дүгээр захирамжийн хавсралт

"НАУРЫЗ-2019" БАЯРЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Арга хэмжээ	Мөнгөн шагнал
1	Казах үндэсний хувцас шалгаруулах тэмцээний зардал, шагнал	1,320,000
2	"Наурыз"-ын баярын казах үндэсний концерт бэлтгэн тоглуулах ажиллагааны зардал	1,020,000
3	Казак үндэстэний өв соёлыг сурталчлах арга хэмжээний зардал	750,000
4	Хөдөлмөр бүтээлийн Есөн алдартан шалгаруулах ажиллагааны зардал	1,170,000
5	Залуучуудын дунд бата /ерөөл/, домборын аялгуу тэмцээн зохион байгуулах арга хэмжээний зардал, шагнал	590,000
6	Үндэсний урлагийн залуучуудын дэвжээ тэмцээний шагнал, байрны түрээсийн зардал	400,000
7	/Ховд, Булган, Буянт, Үенч сумуудад "Наурыз"-ын баяраар залуучуудын дунд зохион байгуулах арга хэмжээнд үзүүлэх дэмжлэг	2,500,000
8	Бусад / Анонс, зар сурталчилгаа/	250,000
	Дүн	8,000,000

-оОо-